

ТЭНГЭР ФАНД МЕНЕЖМЕНТ ХХК
МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ДОТООД
ХЯНАЛТЫН БОЛОН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХӨТӨЛБӨР

НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

- 1.1. Энэхүү Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр /цаашид “Хөтөлбөр гэх/ Тэнгэр Фанд Менежмент ХХК /цаашид “Компани” гэх/-ийн бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, бүтэц, зохион байгуулалтад нийцсэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломжийг хангахад оршино.
- 1.2. Хөтөлбөрийг Компанийн удирдлага, бүх ажилчид нэгэн адил дагаж мөрдөнө.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЧИГ ҮҮРЭГ, ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

- 2.1. Дотоод хяналт шалгалт нь хууль дээдлэх, хараат бус, ил тод, шударга, бодитой, хариуцлагатай,хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид байх зарчмыг баримтална.
- 2.2. Дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэх захирлын баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж,компанийн үйл ажиллагааг бүхэлд нь бүрэн хамарсан байна.
- 2.3. Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь компанийн ТУЗ-д шууд захирагдан ажиллах бөгөөд зохион байгуулалтын хувьд бусад албан нэгжээс хараат бус бие даасан байна.
- 2.4. Дотоод хяналт шалгалтыг хууль бусаар хэрэгжүүлэх, ашиглах, хяналт тавихыг хориглоно.
- 2.5. **Хөтөлбөрийн чиг үүрэг**
 - 2.5.1.Харилцагч, бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх үйл ажиллагаанд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх аргачлалыг тогтоох;
 - 2.5.2.Өндөр эрсдэлтэй харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх журмыг тогтоох;
 - 2.5.3.Шинэ технологи болон өндөр эрсдэлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэрийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээний зохицуулалтыг бий болгох;
 - 2.5.4.Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа, харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааны журмыг тогтоох;
 - 2.5.5.Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхэд дагаж мөрдөх зохицуулалтыг тогтоох;
 - 2.5.6.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөл, төрийн болон олон улсын холбогдох байгууллагаас гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх зохицуулалтыг тогтоох;
 - 2.5.7.Тусгайлан хяналт тавих үйл ажиллагааны журмыг тогтоох;
 - 2.5.8.Корреспондент банкны харилцаа тогтоох журмыг зохицуулах;
 - 2.5.9.Мөнгөн гуйвуулга, цахим төлбөр тооцоог гүйцэтгэхэд баримтлах журмыг тогтоох
 - 2.5.10. Сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээллийн нууцлалыг хадгалах, Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий бусад байгууллагад мэдээлэл өгөх, баримт бичиг шилжүүлэх, хадгалах журмыг тогтоох;
 - 2.5.11. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий албан тушаалтныг томилох, чөлөөлөх журам, түүний эрх, үүргийг тогтоох;

2.5.12. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, холбогдох бусад журмын хэрэгжилтийг хангахад чиглэсэн дотоод сургалтын хөтөлбөрийн шаардлагыг тусгах;

2.5.13. Хуульд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актад заасан бусад нөхцөл, шаардлагыг тусгах.

2.6. Компани, ТУЗ, Гүйцэтгэх захирлын чиг үүрэг

2.6.1. Дотоод хяналтын ажилтныг ажиллах нөхцөл боломжоор хангах;

2.6.2. Журмын дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэх удирдамж, жилийн төлөвлөгөөг батлах, үр дүн тайлантай танилцах;

2.6.3. Дотоод хяналт шалгалтын дүн, тайлантай танилцаж, санал боловсруулах, шийдвэр гаргах;

2.6.4. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг арилгах асуудлаар санал зөвлөмж, шийдвэр гаргах;

2.6.5. Дотоод хяналт шалгалтыг дээшлүүлэх, үр нөлөө, мэргэжлийн чадавхыг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах; зөрчлийг нь арилгаж чадахгүй асуудлыг хууль хяналтын эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, холбогдох байгууллагатай хамтран ажиллах шийдвэр гаргах;

2.6.6. Шаардлагатай тохиолдолд дотоод хяналт шалгалтыг хамтран хэрэгжүүлэх.

2.7. Дотоод хяналт шалгалт зохион байгуулах хэлбэр

2.7.1. Хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий ажилтан нь хяналт шалгалтыг өөрийн санаачилгаар, эрх бүхий албан тушаалтны даалгаснаар түүнчлэн хуулиар хориглосноос бусад аль ч хэлбэрээр явуулж болно.

2.7.2. Дотоод хяналт шалгалтыг Дотоод хяналтын ажилтан ганцаарчлан эсхүл Компанийн удирдлагатай хамтран явуулж болно.

2.7.3. Дотоод хяналт шалгалтын үйл явц, үр дүнг тэмдэглэл үйлдэн гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

2.7.4. Дотоод хяналтын ажилтан нь хяналт шалгалт хийх болсон тухай шалгуулах этгээдэд урьдчилан мэдэгдэж болно.

2.7.5. Хяналт шалгалтын дүнг шалгуулсан ажилтанд танилцуулж, холбогдох баримт бичигт гарын үсэг зуруулна. Гарын үсэг зурахаас татгалзсан нөхцөлд шалтгааныг бичиж, тэмдэглэл үйлдэж баталгаажуулна.

ГУРАВ. ДОТООД ХЯНАЛТЫН АЖИЛТАН

3.1. Дотоод хяналтын ажилтан Хөтөлбөрт заасан чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

3.2. Дотоод хяналтын ажилтан Мөнгө угаах болон нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод журамд заасан ажил үүргийн дагуу ажиллана. Үүнд:

3.2.1. Өдөр тутмын харилцагчийн захиалгад хяналт тавих;

3.2.2. СМА болон холбогдох байгууллагад тайлан, мэдээ боловсруулж, хүргүүлэх;

3.2.3. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, дотоод журмын хэрэгжилтийг хариуцах, байнгын хяналт тавих.

3.3. Дотоод хяналтын ажилтан дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

3.3.1. Ажилтнуудаас сэжигтэй гүйлгээний тухай санал, мэдээллийг авч тэдгээрийг Гүйцэтгэх захиралд танилцуулан СМА-д хүргүүлэх;

3.3.2. Хууль эрх зүйн актад нийцүүлсэн МУТСТ бодлогын баримт бичгийг боловсруулан ТУЗ-өөр батлуулж хариуцан ажиллах;

3.3.3. Компанийн удирдлагын МУТСТ соёлыг бий болгож байгууллагад хэвшүүлэн мөрдүүлэх ажилд хяналт тавих;

3.3.4. Дотооддоо сэжигтэй гүйлгээний тайлангуудыг цаг алдалгүй гарган шинжилгээ хийж хяналт тавих;

- 3.3.5. Удирдлага, Ажилтнуудын дунд МУТСТ гэмт хэргийн тухай ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах, хөтөлбөр боловсруулах;
 - 3.3.6. Гүйцэтгэх удирдлагад тайлан, мэдээ танилцуулга бэлтгэж өгөх, зөвлөгөө өгч ажиллах;
 - 3.3.7. ТУЗ-ийн хуралд тайлан, мэдээг танилцуулах;
 - 3.3.8. МУТСТ чиг үүрэг бүхий зохицуулалтын болон хууль хяналтын байгууллагатай харилцахад Гүйцэтгэх захиралтай зөвлөлдөн Компанийг төлөөлөх;
 - 3.3.9. НҮБ, зохицуулалтын байгууллага, эсхүл СМА-аас ирүүлсэн хориг жагсаалтын талаарх мэдээлэлтэй байх;
 - 3.3.10. Зохицуулалтын болон хууль хяналтын байгууллагаас мэдээлэл шаардсан тохиолдолд Гүйцэтгэх захиралд мэдэгдэн цаг алдалгүй гаргаж өгөх;
 - 3.3.11. Холбогдох хууль, дүрэм журамд өөрчлөлт орсон тохиолдолд компанийн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр, дотоод журмыг шинэчлэн боловсруулах.
- 3.4. Компанийн үйл ажиллагааны онцлог, бүтцийг харгалзан тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг Дотоод хяналтын ажилтан боловсруулан Гүйцэтгэх захирлаар батлуулан мөрдөж ажиллана.
- 3.5. Дотоод хяналтын ажилтныг ТУЗ-ийн санал болгосноор Гүйцэтгэх удирдлага томилно. Дотоод хяналтын ажилтан холбогдох журамд зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна.
- 3.5.1. МУТСТ тухай хууль, дүрэм журмын талаар мэдлэг, туршлагатай байх;
 - 3.5.2. Ашиг сонирхлын зөрчилгүй байх ба гэмт хэрэгт холбогдон ял шийтгэгдэж байгаагүй байх.
- 3.6. Дотоод хяналтын ажилтныг холбогдох баримт бичигт зааснаас гадна дараах үндэслэлийн дагуу ажлаас чөлөөлнө. Үүнд:
- 3.6.1. Өөрийн хүсэлтээр албан тушаалаас болон ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан;
 - 3.6.2. ТУЗ эсхүл Гүйцэтгэх удирдлагын шийдвэрээр;
 - 3.6.3. Ажлын хариуцлага удаа дараа алдсан тохиолдолд холбогдох хууль, дүрэм, журмын дагуу.

ДӨРӨВ. ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ

4.1. Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа.

4.1.1. Харилцагчийг дараах тохиолдолд таньж мэднэ. Үүнд:

4.1.1.1. Гэрээ байгуулахын өмнө;

4.1.1.2. Харилцагчийн талаар өмнө нь авсан мэдээллийн үнэн, зөв эсэхэд эргэлзсэн тохиолдолд;

4.1.1.3. Тухайн харилцагчийг МУТС үйл ажиллагаатай холбоотой гэж сэжиглэсэн тохиолдолд;

4.1.1.4. Бусад.

4.1.2. Харилцагчийн албан ёсны эх сурвалж, баримт бичиг, мэдээ, мэдээллийн эх үүсвэрийг ашиглан харилцагчийг таньж мэднэ.

4.1.3. Харилцагч мэдээлэл өгөхөөс татгалзвал үйлчилгээ үзүүлэхгүй.

4.1.4. Харилцагчийг таньж мэдэхэд дараах мэдээллийг ашиглана. Үүнд:

4.1.4.1. Харилцагч иргэн бол түүний ургийн овог, эцэг /эх/, өөрийн нэр, оршин суугаа хаяг, иргэний үнэмлэх /паспорт/, регистрийн дугаар, холбоо барих утасны дугаар;

4.1.4.2. Харилцагч хуулийн этгээд бол түүний оноосон нэр, албан ёсны хаяг, улсын бүртгэлийн дугаар, харилцах утасны дугаар, төлөөлөн харилцах эрх бүхий албан тушаалтны нэр, хаяг, холбоо барих утасны дугаар;

4.1.4.3. Шаардлагатай гэж үзвэл хууль, журмаар тогтоосон бусад мэдээлэл.

4.1.5. Харилцагч иргэн бол иргэний үнэмлэхийг хуулбарлан авах, гарын үсгийг холбогдох гэрээнд тусган авах ажлыг гүйцэтгэнэ.

4.1.6. Харилцагч хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, удирдлагын талаарх мэдээллийг авна.

4.2. Харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагаа.

4.2.1. Компани Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу хийсэн эрсдэлийн үнэлгээгээр болон Үндэсний эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн хэсэгт харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг нарийвчлан хийнэ.

4.2.2. Компани нь дараах тохиолдлыг өндөр эрсдэлтэйд авч үзнэ:

4.2.2.1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5.9 дугаар зүйлд заасан харилцагчийг;

4.2.2.2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан гүйлгээ хийх тохиолдолд;

4.2.2.3. Цахим шилжүүлэг, корреспондент харилцаанд үндэслэн хийгдэж байгаа гүйлгээ болон улс төрд нөлөө бүхий этгээд гэдэг ангилалд хамаарах харилцагчийн эсхүл харилцагчийн эцсийн өмчлөгч нь улс төрд нөлөө бүхий этгээд байгаа тохиолдолд;

4.2.2.4. Эрх бүхий хяналт, зохицуулалтын байгууллага, Санхүү мэдээллийн албанаас эсхүл Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/, ФАТФ-ын бүс нутгийн байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх өндөр эрсдэлтэй гэж тодорхойлогдсон улс орон, бүс нутагтай холбоотой төлбөр тооцооны гүйлгээ

4.2.2.5. Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг гуравдагч этгээдээр дамжуулан хийсэн эсхүл зайнаас бизнесийн харилцаа үүсгэсэн харилцагчийн төлбөр тооцооны гүйлгээг.

4.2.3. Харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг өндөр эрсдэлтэй харилцагч болон төлбөр тооцооны гүйлгээнд хийнэ.

4.2.4. Харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээг авна /Үүгээр хязгаарлагдахгүй/. Үүнд:

4.2.4.1. Тухайн харилцагчийн эрхэлж буй ажил, бизнес, хөрөнгийн эх үүсвэр, гүйлгээний зориулалт, утга зэрэгтэй холбоотой нэмэлт мэдээллийг гаргуулж авах, боломжийн хэмжээнд эдгээр мэдээллийн үнэн бодит байдлыг нягтлах;

4.2.4.2. Тухайн харилцагчтай бизнесийн харилцааг цаашид үргэлжлүүлэх эсэх талаар Гүйцэтгэх удирдлагын зөвшөөрлийг авна. Энэ зөвшөөрөл нь харилцагчийг хүлээн зөвшөөрөх дотоод журмын хүрээнд явагдах бөгөөд энэ журамд мэдээлэх үүрэгтэй этгээдийн хүлээн зөвшөөрөх хэмжээнээс хэт өндөр мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэл бүхий харилцагч болон үнэн зөв мэдээллийг өгөхөөс зайлсхийсэн харилцагчтай бизнесийн харилцаа үүсгэхээс татгалзах боломжтой зохицуулалтыг оруулсан байх шаардлагатай;

4.2.4.3. Харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг өндөр эрсдэлтэй харилцагчид бүтээгдэхүүн, үйлчилгээ авах бүрт нь холбогдох нэмэлт мэдээллийг авах. Өмнө нь өгсөн мэдээлэлд гарсан өөрчлөлтийг тусгах замаар байнгын үргэлжлэх хэлбэрээр хэрэгжүүлнэ.

4.3. Өндөр эрсдэлтэй харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагаа

4.3.1. Дараах этгээдийг өндөр эрсдэлтэй харилцагч гэж үзнэ. Үүнд:

4.3.1.1. Улс төрд нөлөө бүхий этгээд, түүнтэй адилтгаж болох эрх бүхий этгээдүүд;

4.3.1.2. Улс төрд нөлөө бүхий этгээдтэй нэгдмэл сонирхолтой этгээд;

4.3.1.3. Улс төрд нөлөө бүхий этгээдийн гэр бүлийн гишүүд;

4.3.1.4. МУТСТ чиг үүрэг бүхий ОУ-ын байгууллагаас МУТСТ хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улсын хүн, хуулийн этгээд;

4.3.1.5. МУТСТ үндэсний эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хүн, хуулийн этгээд;

4.3.1.6. Улс төрд нөлөө бүхий этгээдийн нэр дээр хийсэн гүйлгээ.

4.3.2. Хөтөлбөрийн 4.3.1-т заасан этгээдийн шаардлагатай нэмэлт мэдээллийг авах ажиллагааг хийж гүйцэтгэнэ.

4.4. Улс төрд нөлөө бүхий этгээд

4.4.1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйл болон энэ журмын заасан дотоод хяналтын хөтөлбөр нь улс төрд нөлөө бүхий этгээд, түүний гэр бүлийн гишүүд болон хамаарал бүхий этгээд болон нэгдмэл сонирхол бүхий этгээдийг тодорхойлох, тэдгээрийг харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагаанд хамруулах, тэдгээрийн нэр дээр хийгдэж байгаа гүйлгээнд тусгайлан хяналт тавих арга хэмжээг тусгасан байна.

4.4.2. Компани нь харилцагчийн эцсийн өмлөгч нь улс төрд нөлөө бүхий этгээд мөн эсэхийг тодорхойлох арга хэмжээ авна.

4.4.3. Улс төрд нөлөө бүхий этгээдийн бүлийн гишүүд, хамаарал бүхий этгээд болон нэгдмэл сонирхолтой этгээдийг улс төрд нөлөө бүхий этгээдийн нэгэн адил авч үзнэ.

4.4.4. Компани нь хэрвээ өндөр эрсдэлтэй гэж үзэхээр байгаа бол даатгалын нөхөн төлбөр төлөхөөс өмнө дээд шатны удирдлагад мэдэгдэх, даатгуулагчтай тогтоосон бизнесийн харилцаа бүхэлд нь тусгайлан нягтлах болон сэжигтэй гүйлгээний тайлангаар мэдээлэх арга хэмжээг авах шаардлагатай.

4.4.5. Компани нь улс төрд нөлөө бүхий этгээдтэй холбоотойгоор хяналт зохицуулалтын эрх бүхий байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийг дагаж мөрдөнө.

4.5. Эцсийн өмчлөгчийг тогтоох

4.5.1. Харилцагч өөрийгөө эсхүл нэг болон түүнээс дээш эцсийн өмчлөгчийг төлөөлж байгаа эсэхийг тодорхойлж, эцсийн өмчлөгчийг таньж мэдэх шаардлагатай арга хэмжээг авна.

4.5.2. Эцсийн өмчлөгч, харилцагчийн эзэмшилд байгаа хөрөнгийн ашиг шимийг хүртэгч этгээд, гэрээ хэлцлийн дагуу хөрөнгийн хөрөнгөө шилжүүлэн, шийдвэр гарган удирддаг эсхүл ашиг шимийг хүртэгч этгээдийг тодорхойлох боломжит бүх арга хэмжээг авах бөгөөд эцсийн өмчлөгчийг тогтоосон гэж үзэх хүртлээ найдвартай эх сурвалжаас шаардлагатай мэдээллийг авч ашиглана.

4.5.3. Эцсийн өмчлөгчийн талаар авах мэдээлэл нь энэ журмын хавсралт Хүснэгтүүд дэх шаардлага болон холбогдох бусад журам, зааврын шаардлагыг хангасан байна.

4.5.4. Хувьцаа эзэмшигчдийн мэдээллээ ил тод байлгах үүрэг хүлээсэн хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд (хуулийн этгээд эсхүл эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд), мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үр дүнтэй хяналт шалгалт хийгддэг гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаа эзэмшигчдийн мэдээллээ ил тод байлгах үүрэг хүлээсэн хувьцаат компаниудын тухайд 1,2,3-р Хүснэгтэд дурдсан мэдээллийг авах бөгөөд харилцагчийг тодорхойлох нэмэлт мэдээлэл шаардахгүй байж болно.

4.5.5. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үр дүнтэй хяналт шалгалт хийгддэг гадаад улсыг тодорхойлохдоо Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/, ФАТФ-ын бүс нутгийн байгууллага, Олон улсын валютын сан, Дэлхийн банкнаас гаргасан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандартыг зохистой түвшинд хэрэгжүүлдэг талаарх тайлан, үнэлгээг харгалзан үзэх шаардлагатай.

4.5.6. Эцсийн өмчлөгчийг тогтоохдоо Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасан дарааллыг баримтална. 41.1,1-д заасан дийлэнх хэсэг гэдгийг шууд болон шууд бус хэлбэрээр нийт хувьцааны 33 хувийг өмчилж байгаа гэж ойлгоно.

4.5.7. Хөрөнгийг удирдах хэлцэл болон эрх зүйн зохицуулалт бүхий этгээдийн хувьд эцсийн өмчлөгчийг тодорхойлох боломжит бүх арга хэмжээг авахдаа дараах мэдээллийг авна.
Үүнд:

4.5.7.1. Хөрөнгийг гэрээний дагуу шилжүүлж байгаа этгээд /Settlor/;

4.5.7.2. Траст гэрээгээр хөрөнгийг захиран зарцуулах байгаа этгээд эсхүл хэд хэдэн этгээд /Trustee(s)/ ;

4.5.7.3. Траст /хөрөнгө итгэмжлэн удирдах/ гэрээний ашиг шимийг хүртэгч /beneficiary(s)/ ;

4.5.7.4. Хэрвээ байгаа бол гэрээний ашиг шимийг хүртэгчийг хамгаалах “protector”-ын мэдээллийг гаргуулан авна.

4.5.7.5. Дээрхээс өөр төрлийн гэрээ хэлцлийн хувьд дээрхтэй ижил байр суурин дээр байгаа хувь хүмүүсийг тогтоох үйл ажиллагааг хийнэ.

4.5.8. Шууд бус өмчлөгчийг тогтоох

4.5.8.1. Бүх төрлийн хуулийн этгээд эсхүл трастын гэрээ болон ижил төстэй гэрээ хэлцлээр эзэмшиж байгаа хувьцааны хувийг тэдгээрийн хувьцаа эзэмшигч эсхүл ашиг шимийг хүртэгч этгээд /бүлэг этгээдүүдийн/ хувьцаа гэж тооцно.

4.5.8.2. Гэр бүлийн нэг гишүүний эзэмшиж байгаа хувийг гэр бүлийн бусад гишүүдийн эзэмшиж байгаа хувьтай нэгтгэн бүхэлд нь авч үзнэ.

4.6. Харилцагчийг таньж мэдэх хялбаршуулсан үйл ажиллагаа

4.6.1. Харилцагч нь төрийн болон нутгийн захиргааны байгууллага, эсхүл хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгчийг ил тод мэдээлэх үүрэгтэй хөрөнгийн биржид бүртгэлтэй компани, эсхүл ижил түвшний урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулдаг мэдээлэх үүрэгтэй этгээд бол Компани нь харилцагчийг таньж мэдэх хялбаршуулсан үйл ажиллагааг хийж болно.

4.6.2. Харилцагчийг таньж мэдэх хялбаршуулсан үйл ажиллагаанд нь дараах үйл ажиллагаа орж болно.

4.6.2.1. Харилцагчийг тодорхойлох мэдээлэлд орсон өөрчлөлтийг шинэчлэх давтамжийг багасгах;

4.6.2.2. Гүйлгээнд тавих байнгын хяналт тавих болон гүйлгээтэй холбоотой нэмэлт мэдээлэл цуглуулах түвшнийг бууруулах;

4.6.3. Харилцагч, эсхүл гүйлгээг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэсэн эсхүл мэдээлэх үүрэгтэй этгээд, хяналт шалгалтын чиг үүрэгтэй эрх бүхий байгууллага, Санхүү мэдээллийн албанаас өндөр эрсдэлтэй гэж үзсэн бизнес, улс оронтой холбоотой харилцагчид харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хялбаршуулсан байдлаар хийхгүй.

ТАВ. ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ГУРАВДАГЧ ЭТГЭЭДЭЭР ГҮЙЦЭТГҮҮЛЭХЭД ДАГАЖ МӨРДӨХ ЗОХИЦУУЛАЛТ

5.1. Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхэд /цаашид “Гуравдагч этгээд” гэх/ тухайн этгээдтэй энэ талаарх харилцааг зохицуулсан гэрээ, нууц хадгалах гэрээг байгуулна.

5.2. Гуравдагч этгээдийг ТУЗ сонгож Гүйцэтгэх захирал гэрээ байгуулна.

5.3. Дотоод хяналтын ажилтан, Комплайнсын ажилтан болон бусад шаардлагатай ажилчид Гуравдагч этгээдэд Компанийг төлөөлөн ажиллана.

5.4. Харилцагчийн мэдээллийг Гуравдагч этгээдэд шилжүүлэх тохиолдолд энэ тухай дотоод хяналтын ажилтан Гүйцэтгэх захиралтай зөвшилцөнө.

5.5. Компани нь харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлсэн тохиолдолд доорх хориг арга хэмжээг хэрэгжүүлж мөрдөж ажиллана.

- 5.5.1.Компани нь харилцагчийг таньж мэдэх, эцсийн өмчлөгчийг тогтоох, бизнесийн үйл ажиллагааны бодит байдлыг ойлгох үйл ажиллагааг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлж болно.
- 5.5.2.Харилцагчийг таньж мэдэхтэй холбоотой бүх хариуцлагыг гуравдагч этгээдээр дамжуулан харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хийж байгаа компани өөрөө хүлээнэ.
- 5.5.3.Компани нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлсэн тохиолдолд гуравдагч этгээд нь харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан бүх баримт, мэдээллийг мэдээлэх үүрэгтэй этгээдэд нэн даруй хүргүүлэх эсхүл ирүүлэхийг хүссэн даруйд гаргаж өгөхөд бэлэн байлгах шаардлагатай.
- 5.5.4.Гуравдагч этгээдтэй хийсэн харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хийлгэх тохиролцоо нь баримтжуулсан байх шаардлагатай бөгөөд хяналт зохицуулалтын эрх бүхий байгууллагын хүсэлтээр гаргаж өгөхөд бэлэн байна.
- 5.5.5.Гуравдагч этгээдтэй харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хийлгэх тохиролцоонд хүрэхийн өмнө гуравдагч этгээдийн байрлаж буй улс, орны мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг харгалзан үзэх шаардлагатай.
- 5.6. Компанийн харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа хийлгэх гуравдагч этгээд нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 5.6.1.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн хяналт, зохицуулалтад хамрагддаг, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үүрэг хүлээсэн этгээд байх;
 - 5.6.2.Харилцагчийг таньж мэдэх бодлого, журам нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон энэ журмын шаардлагуудтай нийцтэй байх;
 - 5.6.3.Баримт, мэдээллийг хадгалах үүрэг нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон энэ журмын шаардлагуудтай нийцтэй байх.

ЗУРГАА. ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ

- 6.1. Дотоод хяналтын ажилтан Харилцагч, бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх үйл ажиллагаанд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэн тогтоож Гүйцэтгэх захиралд танилцуулах ажлыг зохион байгуулна.
- 6.2. Эрсдэлийн үнэлгээг хийхэд Харилцагчаас хамаарах, Газар зүйн, Терроризм, террорист үйл ажиллагааг санхүүжүүлэх, дэмжихэд тохиромжтой гэж үзсэн улс орон, бүс нутаг, Бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчдад хүргэх арга хэлбэр, Бизнесийн харилцааны, Төлбөр төлөхтэй холбоотой гүйлгээний зэрэг эрсдэлийн хүчин зүйлсийг харгалзан үзнэ.
- 6.3. Харилцагчаас хамаарах эрсдэлийн хүчин зүйлсийг үнэлэхэд дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ. Үүнд:
 - 6.3.1.Харилцагч өөрийн биеэр ирэлгүй зайнаас харилцаа үүсгэсэн;
 - 6.3.2.Тухайн газар нутагт амьдардаггүй түр оршин суугч, гадаадын иргэн;
 - 6.3.3.Харилцагч хуулийн этгээд эсхүл хэн нэгнийг төлөөлж буй буюу хөрөнгийг удирдах, итгэмжлэн удирдах хэлцлийн дагуу хөрөнгийг хариуцаж байгаа этгээд;
 - 6.3.4.Ойлгоход төвөгтэй өмчлөлийн хэлбэртэй хуулийн этгээд.
- 6.4. Газар зүйн эрсдэлийн хүчин зүйлсийг үнэлэхэд дараах хүчин зүйлсийг харгалзана.Үүнд:
 - 6.4.1.МУТСТ тогтолцооны төвшин сул улс орнууд /Монгол Улс хамаарахгүй/;
 - 6.4.2.Санхүүгийн болон бусад хориг эсхүл ижил төрлийн арга хэмжээнд хамрагдсан, авлига хээл, хахууль, гэмт хэргийн үзүүлэлт өндөр улс орнууд;
 - 6.4.3.Терроризм, террорист үйл ажиллагааг санхүүжүүлэхэд, дэмжихэд тохиромжтой гэж үзсэн улс орон, бүс нутаг;

- 6.4.4. Авлига хээл хахууль болон бусад гэмт хэргийн үзүүлэлт өндөртэй гэж тодорхойлогдсон улс орнууд.
- 6.5. Бүтээгдэхүүн, үйлчилгээ, гүйлгээтэй холбоотой эрсдэлийн хүчин зүйлсийг үнэлэхэд дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ. Үүнд:
- 6.5.1. Зайнаас үйлчилгээ үзүүлдэг эсэх (Тухайлбал аппликешн ашигладаг эсэх);
- 6.5.2. Хүлээн авагч эсхүл шилжүүлэгчийн нэр тодорхойгүй гүйлгээ болон бэлэн мөнгөний гүйлгээ;
- 6.5.3. Үл мэдэгдэх эсхүл хамааралгүй гуравдагч этгээдийг оролцуулан хийх төлбөр тооцоо болон бусад гүйлгээ.
- 6.6. Компани эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх замаар эрсдэлийг удирдана. Үүнд:
- 6.6.1. Харилцагч, эцсийн өмчлөгч, ашиг шимийг хүртэгч этгээд нартай холбоотой нэмэлт мэдээлэл гаргуулж авах;
- 6.6.2. Харилцагч түүний эцсийн өмчлөгчийн талаар хангалттай мэдээлэлтэй байх. Энэ хүрээнд компанитай үүсгэж буй бизнесийн харилцааны зорилго, хөрөнгө орлогын гарал, үүсэл, харилцагчийн эрхэлдэг ажил бизнесийн хүрээний талаар мэдээлэл гаргуулсан байна.
- 6.6.3. Өндөр эрсдэлтэй гэж үзсэн харилцагч, бүтээгдэхүүн үйлчилгээ тэдгээрийг харилцагчдад хүргэх арга хэлбэр болон газарзүйн байрлалтай уялдуулан харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагаа авч хэрэгжүүлнэ.
- 6.6.4. Харилцагчтай үүсгэсэн санхүү бизнесийн харилцаа болон төлбөр тооцоо, гүйлгээний талаар мэдээлэл хөтөлнө.
- 6.6.5. Санхүүгийн зохицуулах хороо болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 19.1 дэх хэсэгт заасан бусад эрх бүхий байгууллагаас баталсан заавар зөвлөмжийг дагаж мөрдөнө.
- 6.7. Дотоод эрсдэлийн үнэлгээг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон Монгол банкны “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-д заасныг удирдлага болгон үр дүнг Гүйцэтгэх удирдлагад танилцуулна.
- 6.8. Эрсдэлийг үнэлэх аргачлал

Харилцагч, бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчдад хүргэх үйл ажиллагаанд мөнгө угаах эрсдэлийг тодорхойлох шалгуур үзүүлэлтийн асуулт тус бүрд өгөх үнэлгээ				
0-1 эрсдэлгүй	2 бага эрсдэлтэй	3 дунд эрсдэлтэй	4 өндөр эрсдэлтэй	5 бодит эрсдэлтэй

- 6.9. Эрсдэлийг үнэлэхэд энэхүү Хөтөлбөрт тусгасан арга, аргачлалыг ашиглахаас гадна Компанийн Комлайнсын хөтөлбөрт тусгагдсан эрсдэлийг үнэлэх арга, аргачлалыг ашиглаж болно.

ДОЛОО. ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

- 7.1. Өндөр эрсдэлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэрийн эрсдэлийг бууруулах чиглэсэн арга хэмжээг авч ажиллана.
- 7.2. Өрийн хэрэгслийн бүтээгдэхүүнийг зах зээлд гаргах тохиолдолд өрийн хэрэгслийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах хангалттай хэмжээний Барьцаа, Баталгааг гаргуулна. Өрийн хэрэгслийн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар Батлан даалтын гэрээг дангаар байгуулахыг хориглоно.
- 7.3. Компани зах зээлд гаргаж буй аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар харилцагчийн авахыг хүссэн Компанийн нууцад хамаарахаас бусад мэдээллийг үнэн зөвөөр гаргаж өгнө.

НАЙМ. КОРРЕСПОНДЕНТ БАНКНЫ ХАРИЛЦАА

- 8.1. Корреспондент банкны харилцаа тогтоох асуудлыг Монгол банкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам” Компанийн мөнгө угаах , терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх дотоод үйл ажиллагааны журам”-аар зохицуулна.

ЕС. ХОРИГ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОХИЦУУЛАЛТ

- 9.1. Дотоод хяналтын ажилтан, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөл, төрийн болон олон улсын холбогдох байгууллагаас гаргасан хориг арга хэмжээний талаар мэдээлэлтэй байна.
- 9.2. Компани харилцагчтай бизнесийн харилцаа тогтоож эхлэх үед дотоод хяналтын ажилтан Харилцагчийг Хөтөлбөрийн 8.1-г заасан байгууллагын хориг арга хэмжээд орсон эсэхэд хяналт хийж Гүйцэтгэх удирдлагад мэдэгдэнэ.
- 9.3. Хөтөлбөрийн 8.1-г заасан этгээд Компанийн харилцагч болох, бизнесийн үйл ажиллагаа эхлүүлэхийг хүссэн тохиолдолд Гүйцэтгэх захиралтай зөвлөлдөн СМА-д мэдээлнэ.

АРАВ. ТУСГАЙЛАН ХЯНАЛТ ТАВИХ

- 10.1. Дотоод хяналтын ажилтан дараах хяналт шалгалтыг тогтмол хийж гүйцэтгэх ажлыг зохион байгуулна.
- 10.1.1. Өдөр тутмын гүйлгээнд хяналт тавих;
 - 10.1.2. Сар бүр сэжигтэй гүйлгээний тайланг гэрээ болон захиалгатай тулгаж хянах;
 - 10.1.3. Өндөр эрсдэлтэй харилцагч болон гүйлгээнд хяналт тавих;
 - 10.1.4. Ажилтнууд МУТСТ ажлын эрсдэлд суурилсан механизмыг өдөр тутмын ажилдаа хэрэгжүүлж буйд хяналт тавих.
- 10.2. Компани дараах гүйлгээнд тусгайлан хяналт тавина. Үүнд:
- 10.2.1. Огцом өөрчлөгдсөн их дүнтэй;
 - 10.2.2. Эдийн засаг, хууль зүйн илт үндэслэлгүй;
 - 10.2.3. Жлс төрд нөлөө бүхий этгээдийн нэр дээр хийсэн;
 - 10.2.4. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж тодорхойлогдсон улсаар дамжуулан хийсэн.
- 10.3. Гүйцэтгэх захирал, ажилтнууд МУТСТ журам дүрмийг тасралтгүй сахин мөрдөж хэрэгжүүлж буйд хяналт тавьж ажиллана.
- 10.4. Гүйцэтгэх захирал Хөтөлбөр Компанийн эрсдэлийн түвшин, онцлогт тохирч буй эсэх, үр дүнтэй эсэхэд хяналт тавина.
- 10.5. Дотоод хяналтын ажилтан Компанийн "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай дотоод журам"-ын биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулна.
- 10.6. Гүйцэтгэх захирал Компанийн түвшинд бодлогын баримт бичиг, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих ба холбогдох хууль журамд өөрчлөлт орсон тохиолдолд холбоотой шинэчлэл өөрчлөлтүүдийг хийж буй эсэхэд хяналт тавина.

АРВАН НЭГ. МӨНГӨН ГУЙВУУЛГА, ЦАХИМ ТӨЛБӨР ТООЦООГ ГҮЙЦЭТГЭХ

- 11.1. Компани харилцагчийн төлбөр тооцоог түүний өмнөөс, бэлэн мөнгөөр гүйцэтгэхийг хориглоно.
- 11.2. Харилцагчийн төлбөр тооцоог түүний захиалгыг үндэслэн гүйцэтгэнэ.
- 11.3. Цахим төлбөр тооцоог харилцагчийн захиалгыг үндэслэн захиалгын мэдээллийг төлбөр тооцоо гүйцэтгэх байгууллагад илгээнэ.
- 11.4. Харилцагч өөрийн данснаас мөнгөн хөрөнгөө авахыг хүссэн тохиолдолд гагцхүү уг хүсэлтийг үндэслэн түүний нэр дээрх арилжааны банкны дансанд цахимаар шилжүүлнэ.

АРВАН ХОЁР. СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭГ ИЛРҮҮЛЭХ, МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛЫГ ХАДГАЛАХ

- 12.1. Сэжигтэй үйлдэл болон гүйлгээг дараах байдлаар таньж мэднэ. Үүнд:
 - 12.1.1. Харилцагч хуурамч бичиг баримт, мэдээлэл өгсөн бол;
 - 12.1.2. Харилцагч мэдээлэл өгөхөөс татгалзсан тохиолдолд;
 - 12.1.3. НҮБ-ын аюулгүйн зөвлөлөөс баталсан террорист эсхүл террорист байгууллага, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой гэж тодорхойлогдсон хувь хүн, хуулийн этгээдийн жагсаалттай харилцагчийн нэр тохирч байвал сэжигтэй гүйлгээний тайланг Гүйцэтгэх захиралд мэдэгдэн СМА-д хүргүүлнэ.
- 12.2. Мэдээллийг нууцлалыг хадгалах.
 - 12.2.1. СМА болон МУТСТ чиг үүрэг бүхий байгууллагаас бусад этгээдэд харилцагчийн мэдээллийг өгөх, дамжуулахыг хориглоно.
 - 12.2.2. Компанийн ажилчид албан үүргийнхээ дагуу олж авсан харилцагчтай холбоотой мэдээллийн нууцлалыг хуульд зааснаас бусад тохиолдолд бүрэн эрхийнхээ хугацаанд болон ажлаас чөлөөлөгдсөнөөс хойш задруулахыг хориглоно.
 - 12.2.3. Ажилчид гүйлгээг сэжигтэй гэдгийг мэдсэн бол харилцагчид мэдэгдэлгүйгээр дотоод хяналт хариуцсан ажилтанд мэдээлэх үүрэгтэй.
- 12.3. Мэдээллийн нууцлал аюулгүй байдал
 - 12.3.1. Мэдээлэх үүрэгтэй этгээд, түүний удирдлага болон ажилтан нь Санхүү мэдээллийн албанд холбогдох хууль, журмын дагуу сэжигтэй гүйлгээ, үйл ажиллагааны талаар мэдээлсэн, нэмэлт мэдээлэл гаргаж өгсөн, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой шалгагдаж байгаа тухай аливаа хэлбэрээр харилцагчид өөрт нь болон бусад гуравдагч этгээдэд мэдээлэл дамжуулах, задруулах нь мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг зөрчсөн гэж үзэх үндэслэл болно. Энэ заалт нь Компани түүний удирдлагууд, болон ажилтан хоорондын харилцаа, хуульчид, эрх бүхий байгууллага, Прокурорын байгууллагад мэдээлэл дамжуулах болон солилцох, харилцаанд хамаарахгүй.
 - 12.3.2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу данс, гүйлгээг царцаах, сэжиглэхтэй холбоотой мэдээллийг эрх бүхий байгууллагын ажилтнаас бусад аливаа хувь хүн, хуулийн этгээдэд задруулж үл болно.
 - 12.3.3. Компани, түүний удирдлага болон ажилтан нь Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий байгууллагад хууль, журамд заасны дагуу мэдээлэл өгснийг банкны, мэргэжлийн, мэргэжлийн үйл ажиллагааны, үйлчлүүлэгчийн, аж ахуйн нэгж, байгууллагын, бизнесийн болон хувь хүний нууцыг задруулсан гэж үзэхгүй. Мэдээлэх үүрэгтэй этгээд, түүний удирдлага болон ажилтны өгсөн мэдээлэл мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй бодит хамааралтай эсэхээс үл хамааран Эрүүгийн, Иргэний болон Захиргааны хууль тогтоомжид заасан аливаа хариуцлагад татах үндэслэл болохгүй.
 - 12.3.4. Хуульд өөрөөр заагаагүй бол Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон энэ журмын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Компани СЗХ-ны хянан шалгагч болон бусад эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангахад санхүүгийн байгууллагын нууцлалтай холбоотой аливаа зүйл, заалт хамаарахгүй.
 - 12.3.5. Компани нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль болон энэ журмыг хэрэгжүүлэх зорилгоор корреспондент банк, цахим шилжүүлэг, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг гуравдагч этгээдэд тулгуурлахтай холбоотой мэдээлэл солилцох ажиллагааг энэ журмаар хязгаарлахгүй.
- 12.4. Компани нь сэжигтэй гүйлгээний тайланг мэдээлэх үүрэгтэй ажилтны аюулгүй байдал, мэдээллийн нууцлалыг хангаж ажиллана.

- 12.5. Сэжигтэй гүйлгээний тайлангаар мэдээлэхэд ямар нэгэн хязгаарлалт, үнийн дүн хамаарахгүй байж болно.
- 12.6. Сэжигтэй гүйлгээний тайлан мэдээллийг хянаж хууль, журамд заасны дагуу Монгол банкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албанд Гүйцэтгэх захиралтай зөвлөлдөн илгээнэ.

АРВАН ГУРАВ. СМА БОЛОН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГАД МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ, БАРИМТ БИЧИГ ШИЛЖҮҮЛЭХ, ХАДГАЛАХ ЖУРАМ

- 13.1. Хорин сая төгрөг /20,000,000₮/, түүнээс дээш бэлэн мөнгөний гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын 5 өдрийн дотор Гүйцэтгэх захиралд тайлагнан батлагдсан маягтын дагуу СМА-д мэдээлнэ.
- 13.2. Харилцагч МУТС эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, мэдсэн бол уг сэжигтэй гүйлгээний тухай 24 цагийн дотор Гүйцэтгэх захиралд мэдэгдэн батлагдсан маягтын дагуу СМА-д мэдээлнэ. Үүнд ямар нэгэн хязгаарлалт үнийн дүн хамаарахгүй.
- 13.3. Сэжигтэй гүйлгээний тайланг мэдээлэхдээ уг гүйлгээтэй холбогдох бусад баримт материал болон нэмэлт мэдээллийг хавсарган СМА-д хүргүүлнэ.
- 13.4. Батлагдсан журмын дагуу тодорхой гүйлгээ, түүнд оролцогч талуудын тухай мэдээллийг эрх бүхий хууль сахиулах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагад мэдэгдэл, тогтоолын дагуу гаргаж өгнө.
- 13.5. Харилцагчийн олж авсан мэдээлэл, баримт материал, гүйлгээний мэдээллийг тав /5/-аас доошгүй жилийн хугацаанд хадгална.
- 13.6. Харилцагчтай холбоотой мэдээлэл, баримт материалыг эрх бүхий байгууллагын хүсэлтээр шуурхай гаргаж өгөхөд бэлэн байдалтай хадгална.
- 13.7. Дотоод хяналтын ажилтан сэжигтэй гүйлгээний тайлан, мэдээг хянаж нэгтгэх ажлыг зохион байгуулна.
- 13.8. Тайлан, мэдээлэлтэй холбоотой мэдээллийг цааш нь задруулахгүй байх тал дээр хяналт тавина.
- 13.9. Тайлан мэдээ болон шалгалттай холбоотой баримт бичгийг бүртгэж хадгална. Үүнд:
 - 13.9.1. Цаасан хэлбэрээр Компанийн архивд хадгалах;
 - 13.9.2. Цахим хэлбэрээр вирус халдаахгүйгээр аюулгүй хадгалах.
- 13.10. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналт болон мэдээлэл солилцох системийг Компанийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээний онцлогт тохируулан сайжруулах саналыг удирдлагад танилцуулж холбогдох саналыг оруулна.
- 13.11. Дотоод хяналтын ажилтан эсхүл Комплайнсын ажилтан Зохицуулагч байгууллага, хууль хяналтын байгууллага зэрэг гаднын байгууллагатай Гүйцэтгэх захиралтай зөвлөлдөн Компанийг төлөөлж ажиллана.

АРВАН ДӨРӨВ. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

- 14.1. Комплайнсын ажилтан Дотоод хяналтын ажилтантай хамтран сургалтын хөтөлбөрийг боловсруулж, сургалтыг тогтмол зохион байгуулна.
- 14.2. Сургалтын агуулгыг ажилчдын ажил үүргийн онцлогийг харгалзан өөр өөр байж болно.
- 14.3. МУТСТ хууль эрх зүйн орчин, холбогдох дүрэм журмууд, хууль, эрх зүйн актад өөрчлөлт орсон тохиолдолд түүний тухай мэдлэг, мэдээллийг тухай бүрд ажилчдад өгнө.
- 14.4. Шинээр ажилд орж буй ажилтныг шаардлагатай Компанийн дотоод сургалтад хамруулна.
- 14.5. МУТСТ зохицуулалтын орчин болох холбогдох эрх зүйн акт, Компанийн дотоод бодлогын баримт бичиг, дүрэм журамд өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээр өөрчлөлтүүдийг сургалтын агуулгад тусгаж өөрчилнө.
- 14.6. Компанийн ажилтнуудын "харилцагчийг таньж мэдэх" болон "мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх" чиглэлээрх мэдлэгийг дээшлүүлэх, сургалтыг Комплайнсын ажилтантай хамтран зохион байгуулах ба хөтөлбөрт дараах асуудлыг тусгана. Үүнд:

- 14.6.1. Сургалт зохион байгуулах давтамж;
 - 14.6.2. Ажилчдын хариуцсан үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулах;
 - 14.6.3. Шинээр орсон ажилтнуудад зориулсан сургалт зэргийг тусгах.
- 14.7. Сургалтын хөтөлбөрийн үйл ажиллагааны тайланг улирал бүр бэлтгэн Гүйцэтгэх захиралд танилцуулан хянуулж ТУЗ-ийн ээлжит хуралд бүрт танилцуулна.

АРВАН ТАВ. БУСАД

- 15.1. Энэхүү журмыг Тэнгэр Фанд Менежмент ХХК-ийн нийт ажилтнууд баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
- 15.2. Хөтөлбөрт ТУЗ нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэнэ.
- 15.3. Гүйцэтгэх захирал, Комплайнсын ажилтан, Дотоод хяналтын ажилтан Хөтөлбөрийн хэрэгжилт, биелэлтэд хяналт тавьж ажиллана.

ooOoo

Тэнгэр Фанд Менежмент ХХК-ийн Мөнгө угаах, терроризмыг
санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын болон эрсдэлийн
удирдлагын хөтөлбөрийн Нэгдүгээр хавсралт

ХАРИЛЦАГЧААС МЭДЭЭЛЭЛ АВАХ, НЯГТЛАХ ЗААВАР

Харилцагч хувь хүн бол нэгдүгээр хүснэгтэд заасан мэдээллийг хүснэгтэд заасан бичиг баримттай тулгах, хуулбарлан авах ажиллагааг гүйцэтгэнэ.

Нэгдүгээр хүснэгт

№	Харилцагчаас авах мэдээлэл	Харилцагчийн мэдээллийг баталгаажуулах
1	Овог, эцэг/эх/-ийн нэр	Иргэний үнэмлэх эсхүл паспорттой тулгах, Иргэний үнэмлэх эсхүл паспортыг хуулбарлан авах,
2	Өөрийн нэр	Иргэний үнэмлэх эсхүл паспорттой тулгах,
3	Төрсөн огноо	Иргэний үнэмлэх эсхүл паспорттой тулгах,
4	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэх эсхүл паспорттой тулгах,
5	Байнгын оршин суудаг газрын хаяг,	Иргэний үнэмлэх эсхүл паспорттой тулгах,
6	Одоо оршин суугаа газрын хаяг, холбоо барих утасны дугаар	Иргэний үнэмлэх эсхүл паспорттой тулгах,
7	Эрхэлж буй ажил, бизнес:	Иргэний үнэмлэх эсхүл паспорттой тулгах,
	1 Бизнесийн чиглэл, цар хүрээг тодруулах	
	2 Ажлын газрын нэр, хаяг, албан тушаалыг тодруулах	

1.1. Харилцагчийг өөр хэн нэг этгээд төлөөлөн данс нээх, гүйлгээх хийх зэрэг үйлдэл хийж байгаа бол доор ажиллагааг гүйцэтгэнэ. Үүнд:

1.1.1. Харилцагч хэн нэгнийг төлөөлж байгаа бол төлөөлүүлэгч этгээдийн нэгдүгээр хүснэгтэд заасан мэдээллийг авна. Төлөөлүүлэгч этгээд нь хувь хүн бол хүснэгт-1, хуулийн этгээд бол Хүснэгт 2, 3-т заасан мэдээллийг гаргуулан авч үнэн бодит эсэхийг нь тодорхойлж, мэдээллийг нь баталгаажуулна.

1.1.2. Харилцагч хуулийн этгээд эсхүл гэрээ хэлцлийг төлөөлж байгаа бол Хүснэгт 2, 3-т заасан мэдээллийг гүйлгээ эсхүл бизнесийн харилцаанд орж буй хөрөнгийн эцсийн өмчлөгчийг тодорхой болох хүртэл гаргуулан авна. Хэрвээ эцсийн өмчлөгч тогтоох боломжгүй өмчлөлийн бүтэцтэй бол шийдвэр гаргаж байгаа, харилцагчийн үйлдлийг удирдан чиглүүлж байгаа хувь хүн тодорхой болох хүртэл гаргуулан авна. Харилцагчаас гаргуулан авсан мэдээллийн бодит байдлыг нотлох баримт бичгийн үнэн, зөв хуулбарыг гаргуулан авч үнэн бодит байдлыг нь хянана.

1.1.3. Харилцагч Траст гэрээгээр бизнесийн харилцаанд орж байгаа бол дараах этгээдийн мэдээллийг харилцагчаас гаргуулан авна. Үүнд:

1.1.3.1. Хөрөнгөө траст гэрээний дагуу бусдад шилжүүлж байгаа этгээд/ Settlor/-ын;

1.1.3.2. Траст гэрээгээр хөрөнгийг захиран зарцуулж байгаа этгээд эсхүл хэд хэдэн этгээд /Trustee(s)/-ын;

1.1.3.3. Траст гэрээний ашиг шимийг хүртэгч /beneficiary(s)/-ын;

1.1.3.4. Байгаа бол гэрээний ашиг шимийг хүртэгчийг хамгаалах “protector”-ын.

1.2. Гэрээний ашиг шимийг хүртэгч нь хуулийн этгээд хэлбэртэй байгаа тохиолдолд уг хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг гаргуулан авна.

1.3. Дээрхээс өөр төрлийн гэрээ хэлцлийн хувьд дээрхтэй ижил байр суурин дээр байгаа хувь хүмүүсийг тогтоох үйл ажиллагааг хийнэ.

2.1. Харилцагч хуулийн этгээд бол хоёрдугаар хүснэгтэд заасан мэдээллийг хүснэгтэд заасан бичиг баримттай тулгах, хуулбарлан авах ажиллагааг гүйцэтгэнэ.

Хоёрдугаар хүснэгт

№	Харилцагчаас авах мэдээлэл	Харилцагчийн мэдээллийг баталгаажуулах
1	Нэр	Улсын бүртгэлийн гэрчилгээтэй тулгах, Улсын бүртгэлийн гэрчилгээг хуулбарлан авах.
2	Улсын бүртгэлийн дугаар	Улсын бүртгэлийн гэрчилгээтэй тулгах,
3	Регистрийн дугаар	Улсын бүртгэлийн гэрчилгээтэй тулгах,
4	Хувьцаа эзэмшигчид	Улсын бүртгэлийн гэрчилгээ, Хуулийн этгээдийн дүрэм, шаардлагатай бол Хуулийн этгээдийг үүсгэн байгуулах баримт бичиг, шийдвэртэй тулгах, Хуулийн этгээдийн дүрмийг хуулбарлан авах.
5	Үйл ажиллагааны чиглэл	Улсын бүртгэлийн гэрчилгээ, Хуулийн этгээдийн дүрэмтэй тулгах
6	Хуулийн этгээдийн хувьцаа эзэмшлийн бүтэц,	Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг тогтооно. Хуулийн этгээдийн нэгдэлд хамаардаг харилцагч хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг тогтоохдоо Өмчлөлийн бүтцийг харуулсан мэдээлэл, уг мэдээлэлд орсон хуулийн этгээд тус бүрийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэмтэй тулгана. Эцсийн өмчлөгч тодорхой болох хүртэлх бүх хуулийн этгээдийг хамруулна.
7	Хуулийн этгээдийн удирдлагын талаарх дэлгэрэнгүй танилцуулга	Улсын бүртгэлд хуулийн этгээдийн бүртгүүлсэн баримт бичиг, уг бүртгэлтэй нийцтэй хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч эсхүл удирдах зөвлөлийн шийдвэр.
8	Үйл ажиллагаа явуулдаг хаяг, холбоо барих утасны дугаар	Харилцагчтай байгуулах гэрээнд тусгуулан Улсын бүртгэлийн гэрчилгээ, Хуулийн этгээдийн дүрэмтэй тулгах
9	Үйл ажиллагаа явуулдаг хаяг, холбоо барих утасны дугаар	Харилцагчтай байгуулах гэрээнд тусгуулан авах.
10	Эцсийн өмчлөгчийн мэдээлэл	Хэрэв эцсийн өмчлөгч нь тухайн хуулийн этгээдэд ямар нэг албан тушаал эрхэлдэггүй бол Хүснэгт 1-ийн дагуу бүх мэдээллийг авах ба тухайн хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч мөн болохыг нотлох баримтын хамт авна.

2.2. Харилцагч хуулийн этгээдийг төлөөлж байгаа бол доорх хүснэгтэд заасан мэдээллийг авч мөн хүснэгтэд заасан бичиг баримттай тулгах, хуулбарлан авах ажиллагааг гүйцэтгэнэ.

Гуравдугаар хүснэгт

№	Харилцагчаас авах мэдээлэл	Харилцагчийн мэдээллийг баталгаажуулах
1	Аливаа этгээдийг төлөөлж буй харилцагч нь хувь хүн бол нэгдүгээр хүснэгтэд заасан мэдээллийг гаргуулан авна.	Хүснэгт-1-т заасан бичиг баримтуудтай тулган баталгаажуулна.
2	Аливаа этгээдийг төлөөлж буй харилцагч нь хуулийн этгээд бол хоёрдугаар хүснэгтэд заасан мэдээллийг гаргуулан авна.	Хүснэгт-2-т заасан бичиг баримтуудтай тулган баталгаажуулна.
3	Эрх зүйн гэрээгээр төлөөлж байгаа бол гэрээний талуудын Улсын бүртгэлийн мэдээлэл, тэр дундаа	Энд дурдсан гэрээний бүх талуудын мэдээллийг хувь хүн бол Хүснэгт 1 хуулийн этгээд бол Хүснэгт 2-ийн дагуу бүрдүүлж үнэн бодит байдлыг нь нягтална.
1	Гэрээнд заасан хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий этгээдийн нэр, хаяг бусад бүртгэлийн мэдээллүүд;	
2	Төлөөлөх эрхтэй этгээдийг томилох, чөлөөлөх эрх бүхий хувь хүн эсхүл хуулийн этгээдийн мэдээллүүд;	
3	Хөрөнгийн ашгийг хүртэх эрхтэй этгээдийн мэдээлэл;	
4	Хөрөнгөө траст гэрээний дагуу бусдад шилжүүлж байгаа этгээд /Settlor/, Траст гэрээгээр хөрөнгийг захиран зарцуулж байгаа этгээд эсхүл хэд хэдэн этгээд /Trustee(s)/,	
5	Траст гэрээний ашиг шимийг хүртэгч /beneficiary(s)/, Хэрвээ байгаа бол гэрээний ашиг шимийг хүртэгчийг хамгаалах “protector”-ын мэдээллийг гаргуулан авна.	
6	Гэрээний ашиг шимийг хүртэгч нь хуулийн этгээд хэлбэртэй байгаа тохиолдолд уг хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг гаргуулан авна.	